

ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ
АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ТЭМДЭГЛЭЛ

2011 оны 04 дүгээр сарын
18-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 03-01

Энэ өдрийн өргөгдсөн хуралдаанд Ө.Оюунбаатар (ЭБМЗ-ийн дарга), М.Ариунбаяр (ЭБМЗ-ийн орлогч дарга), Ц.Амраа (ЭБМЗ-ийн орлогч дарга), М.Тодбилэг (ЭБМЗ-ийн нарийн бичгийн дарга), ЭБМЗ-ийн гишүүд: А.Эрдэнэлүрэв, Д.Алтанхуяг, П.Хүрэлхүү, А.Пүрэв, Д.Алтанчимэг, Х.Санчигдорж, А.Тамираа, Б.Баатарцогт, О.Энхбаяр, Ч.Жамсран, П.Сарангэрэл, Б.Оюун, Т.Багжаргал, А.Түвшинжаргал, А.Бадарч, Х.Отгончимэг, Ч.Чулуунбат, Д.Алтангэрэл, Г.Ухнаа, Ж.Цэвээнжав (нийт 25 гишүүн),

Мөн хуралдаанд хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан БНХАУ-ын Шандун мужийн Доншен Группын Геологийн судалгааны төвийн орлогч дарга Лү Гуанжүн, БНХАУ-ын Шенлигийн газрын тосны товчооны Геологийн шинжлэх ухааны судалгааны хүрээлэнгийн ахлах инженер Юу Гуанхуа, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн ерөнхий захирал Сүн Хуайфу, орлогч захирал Ван Жианлин, санхүүгийн захирал Жау Гэнжү, ерөнхий геологич Сүн Юнчуан, бизнесийн ахлах менежер Жан Цаучи, нягтлан бодогч Жан Вэйли, хятад хэлний орчуулагч П. Чимгээ нар оролцов.

Тухайн өдрийн хуралдааныг ЭБМЗ-ийн дарга Ө.Оюунбаатар, орлогч дарга М.Ариунбаяр нар удирдав.

Хуралдаан 14.00 цагт Эрдэс баялаг, эрчим хүчний яамны хурлын зааланд эхлэв.

Хэлэлцсэн асуудал: Дорноговь аймгийн нутаг дахь Зүүнбаян, Цагаан-элсний бүтээгдэхүүн хуваах гэрээт (91PSC) талбайд гүйцэтгэсэн газрын тосны геологи хайгуулын ажлын үр дүнгийн тайлан”, Доншен газрын тос (Монгол)” ХХК (цаашид “компани” гэх).

Шинжээчдийн дүгнэлт гаргасан: Шинжээчдийн хэсгийн ахлагч А.Эрдэнэлүрэв, гишүүд Ц.Амраа, П.Санж, А.Пүрэв, нарийн бичиг Д.Алтанхуяг нар.

Хуралдааныг даргалагч уг асуудлыг хэлэлцэх эсэх талаар санал хурааж, гишүүдийн 100%-ийн саналаар асуудлыг хэлэлцэхээр тогтов.

ЭБМЗ-ийн хуралдааны дэгийн дагуу Доншен Группын Геологийн судалгааны төвийн орлогч дарга Лү Гуанжүн нөөцийн тайланг танилцуулж, илтгэл хийсэн.

Үүний дараа шинжээчдийн хэсгийн дүгнэлтийг гишүүн А.Пүрэв, шинжээчдийн дүгнэлтэнд өгсөн хариуг компаний зүгээс тус тус уншиж сонсгов.

Асуулт, хариулт:

А.Тамираа: Шинжээчдийн дүгнэлт хэзээ гарсан бэ? Хэр хугацаа зарцуулсан бэ? Яагаад ингэж удсан шалтгаан?

Хариулт

- А.Пүрэв, Д.Алтанхуяг: Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 196 тоот тушаалаар шинжээчид томилогдсон. 2010 оны 8-р сард тайланг хүлээн аваад эхний дүгнэлтийг 2010 оны 11 сарын 25-нд гаргасан. Тайланд засвар, орчуулга хийж, ирүүлсний дараа сүүлийн дүгнэлтийг 2011 оны 3 сарын 10-нд гаргасан.

- Компани: Тайланг эхлээд хятад хэл дээр бичээд дараа нь англи, монгол хэл үрүү орчуулсан тул хугацаа их орсон.

Г.Ухнаа: Шинжээчдийн дүгнэлтэнд нэлээд зүйлс дурьдсан байна. Эдгээрийн хариултыг шүүмжийн 4 дэх заалтаас эхлүүлэн нэг бүрчлэн хариулмаар байна. Зарим блокт дээжлэлт хийлгүй харьцуулж авч болж байна уу?

Хариулт:

- 4. Заавал тэдэн цооног өрөмдөх, тийм судалгаа хийх, ижил байх албагүй.

- 5. Каротажийн багаж нь цацраг идэвхт ашигт малтмалыг илрүүлэх хүчин чадалгүй, харин нүүрс, битум илрүүлэх боломжтой. Каротажийн мэдээнд энэ талаар мэдээлэл гараагүй.

- 6. Усан хангамжийн судалгаа хийгээгүй. Каротажийн судалгаагаар хаана цэнгэг ус, хаана давслаг ус байгаа гэдгийг гаргасан. 200 м-ээс доош гүнд каротаж хэмждэг тул 200 м-ээс дээш манай судалгаанд хамрагдаагүй. Усны шинж чанарыг судлаагүй. Давс ихтэй ус Зүүнбаянгийн сав газарт бий. Усны давхаргыг цооногийн багананд тэмдэглэсэн. Бидний цооног зөвхөн тодорхой талбайд байх тул Зүүнбаянгийн бүх сав газарт ус судлах боломжгүй. 2000 оноос ТЕ-1 (Цагаан элс-1) цооног дээр ус шахах туршилт хийсэн. Ус шахах төлөвлөгөөг 2000 онд ГТГ-г танилцуулсан. Үр дүнгийн тайланг ГТГ-аас шаардаж байсан. 2 талбайд ус шахахад сарын дараа тосны олборлолтын хэмжээ нэмэгдэж, үр дүн сайтай байсан. Нийт 11 цооногт шавхалт хийж, өдөрт 120 баррель тос илүү олборлосон. Ус цэвэршүүлэх, буцаан шахах станц байгуулж байгаа.

- 7. Хөндлөнгийн байгууллагаар нөөцийн тооцоог баталгаажуулаагүй талаар: Манай тайланг 3-дагч байгууллага буюу БНХАУ-ын Шенлигийн Геологийн шинжлэх ухааны судалгааны хүрээлэн хийж, нөөц тооцсон. 3-дагч орноор Монгол Улсын газрын тосны нөөцийг баталгаажуулах боломжгүй. Учир нь: - Газрын тосны нөөц нь тухайн орны нууц байх ёстой, иймд 3-дагч орноор баталгаажуулна гэвэл Монгол Улсын Засгийн Газрын зөвшөөрөл хэрэгтэй.

- Мөн гуравдагч орон нь Монгол Улсын нөөцийн шаардлагыг мэдэхгүй.

- РVT үзүүлэлтийг өндөр даралттай цооногт хийдэг. Зүүнбаянд РVT үзүүлэлт авах үндэслэл байхгүй. Энд Нескорын мэдээг авсан.

- Байгалийн түрэлтээр тос хэдэн хувь байхыг орхисон байсныг тайланд нэмж оруулсан. Байгалийн түрэлтээр оргилох тосны хэмжээг туршилтаар гаргасан. Жишээ нь: 1 км² талбайд 79 цооног байхад байгалийн түрэлт сайн байна.

- 8. Байгаль орчны талаар тайланд тусгасан. Нөхөн сэргээлтийн төлөвлөлт, зарцуулалтыг гаргасан.

Г.Ухнаа: Битүүмжилсэн чөмгөн дээж дутуу авснаас нөөц бодох үзүүлэлт чанаргүй, бусад газрыг төлөөлж чадахгүй гэсэн талаар?

Ц.Амраа: Шинжээчид 3-н блок дээр нөөцийн зэргийг бууруулсан, гэтэл компани баталгаат нөөц гэж оруулжээ, яагаад?

Хариулт: Олон улсын SPE стандартын дагуу баталгаат нөөцөд ангилсан. 3-н хэмжээт чичирхийллийн судалгааны үр дүнг ашигласан. Газрын тосны нөөцийг зөвхөн цооног

өрөмдөж тогтоодог цаг үе өнгөрсөн. 3-н хэмжээст чичирхийллээр нарийн гаргадаг. 25 м-ийн тороор хийсэн. Зүсэлт дээр ус, тосны давхаргыг дүрсэлсэн. Хагарал бас зурагдсан.

Д.Алтанхуяг: Шинжээчдээс геофизикийн асуудал дээр П.Санж гуай ажилласан. Тосны давхарга нь үргэлжилж байгааг цооног өрөмдөхгүйгээр яаж тодорхойлсон, энд 3-н хэмжээст чичирхийллийн судалгаа хангалттай юу? Яаж баталж байна? Ямар дээж авсан? 300-500 м зайд болно гэвэл 1-2 км зайг яаж баглах вэ?

Хариулт

- О.Энхбаяр: Газрын Тосны Газар (ГТГ)-ын Техникийн зөвлөлөөр хэлэлцээд баталгаат нөөцтэй 7 блок байна гэж үзсэн нь Доншен компаний тооцсон нөөцтэй адил юм.

- Т.Батжаргал: Чичирхийлэл дээр давталт 32-62 байдаг бол энд бүр 80 байгаа тул сайн. 25×25 м тортой. 1 км^2 -т байх сувгийн тоо 320 байна. Иймд баталгаат нөөц бодох боломжтой. Хураагуурын зузаан, түүний орших гүн тодорхой үед олон улсын стандартаар зарим тохиолдолд заавал чөмгөн дээж авах шаардлагагүй. 3.6 км зайд 2 цооног бий. 2.5 км зайд 1 цооногтой. Өндөр нарийвчлалтай чичирхийллийн судалгаа хийсэн үед баталгаатаар авах боломжтой гэсэн стандартаар авсан. Мөн зэргэлдээ орших блокторой харьцуулж болно гэсэн байдаг. Гэхдээ зэргэлдээ гэдгээ хэрхэн ойлгох вэ гэдэг нь асуудал юм. Иймд Монгол улсын өөрийн ангилал хэрэгтэй байна. Боломжит, магадтай гэж авсан нь хайгуул хийх шаардлагатай гэсэн үг юм.

Ж.Цэвээнжав: Газрын тосны үнэ 60 ам.доллар байх үеийн нөөцийн хэмжээг тодруулна уу?

Хариулт: 21.5 сая тн байна (Нөөцийн хэмжээг уншиж сонсгов).

М.Тодбилэг: Олон улсын стандартаар авсан гэлээ, гэхдээ энд Монгол орны геологийн нөхцөл, ордын нийлмэл байдал, ордын зэргийг харгалзаж үзсэн биз дээ. Жишээ нь Сибирь, Хятадын платформын ордууд бол том, энгийн тогтоцтой байх.

Хариулт (компани): Зүүнбаян бол энгийн орд.

П.Санж: Олон улсын стандартыг заавал барина гэсэн юм байхгүй. Геофизикийн үр дүн сайтай бол баталгаат нөөцийг заавал олон цооног өрөмдөх шаардлагагүй. Би WTE-1 (баруун Цагаан элс-1) блокийг баталгаат байдлаар ө.х. 5-н блокийг баталгаат гэж дүгнэлт гаргасан.

Ө.Оюунбаатар: Олборлосон нөөцөө хасч тооцсон уу?

Хариулт: хасч тооцсон.

Ө.Оюунбаатар: Хайгуул хийж, нөөцөө бүртгүүлээгүй байхад олборлоод байдаг нь ямар учиртай вэ?

О.Энхбаяр: Олборлолтыг технологийн талаасаа зогсоох боломжгүй байдаг. Энэ тал дээр яам анхаармаар байна. Шинжээч томилохдоо мэргэжлийн хүмүүсийг томилж баймаар байна. Маргаан үүсч байна. Геологийн бүтцийн хувьд баталгаат нөөцөд оруулж болно гэсэн. ГТГ 7 блокийг баталгаат нөөцтэй гэж үзсэн.

ЭБМЗ-ийн гишүүдийн санал, дүгнэлт:

Д.Алтангэрэл: Танилцуулга ойлгомжгүй байна. ГТГ дээр зурган дээр сайн тайлбарлаж байсан боловч энд зөвхөн онол, стандарт талаас ярилаа. Шинжээчийн дүгнэлт бас тодорхойгүй байна. Шинжээчид дотроо санал зөрүүтэй бололтой. Уг нь шинжээчдийн дүгнэлт, компаний санал тодорхой байх ёстой. Өмнө нь Л.Алтангэрэл бид 2 эдгээрийг магадтайгаар авах боломжтой гэсэн. Зүүнбаян нийлмэл, Цагаан элс дээр яагаад 200-300 м-ийн тороор өрөмдсөн. Хятадын шинжээч дүгнэлт хийгээд Цагаан элс-14-г хасч байсан. 250-300 м-ээр өрөмдсөнийг их зайтай байна гэсэн. Мөн “Дачин Тамсаг” дээр 1 блок дээр 1-2 цооног байсныг аваагүй. Үнэхээр баталгаатай бол бүх зураг зүсэлтийг харуулах хэрэгтэй. Шинжээчдийн саналаар авах.

П.Сарангэрэл: Нөөцийн тайлангийн шинжээчийн дүгнэлт үндэслэлээ сайн гаргаагүй байна. Хөндлөнгийн байгууллага ГТГ байхад хөндлөнгийн байгууллага гэсэн асуудал ярих хэрэггүй. Эдийн засаг, байгаль орчин, усны асуудал ТЭЗҮ дээр орно. Энд бол зөвхөн геологийн нөөц ярьж байна. Бүх зардал ГТГ-г байгаа. Компаний оруулснаар нөөцийг авах.

Г.Ухнаа: Учрыг нь олсонгүй. Цооног өрөмдөхгүй болно гэж ярьж байна. Өмнө нь Тамсагийн орд дээр Монгол нийлмэл тогтоцтой гэсэн гэтэл Зүүнбаян, Цагаан элс дээр энгийн тогтоцтой гэж ярьж байгаад итгэхгүй байна. Энэ нь баталгааг нөөцөд хамрана гэдэг, тийм жигдхэн байна гэдэг эргэлзээтэй. Иймд шинжээчийн дүгнэлтээр авах. Тайланг дараа нь авья гэж юу байнаа. Журмын дагуу тайланг авах ёстой.

Ж.Цэвээнжав: Нөөц бол эдийн засгийн ойлголт байдаг. Шинжээчдийн хувилбараар нөөцийг авах. Нөөцийн тархалтын талбай ямар байна, үлдсэн талбайг яах? Компани олон улсын зэрэглэлтэй компани тул тайланг сайн хийсэн байх гэж үзэж байна. Нэг ч Монгол геологи байхгүй. ГТГ өмнөөс нь тайлбар хийж байна.

Ч.Чулуунбат: Газрын тос шингэн ашигт малтмал, иймд шүүр шанага шиг өрөмдөх шаардлагагүй. Шүүр шанага шиг өрөмдвөл олборлолт уруугаа орчихдог. ГТГ-ын техникийн зөвлөлийн саналаар авах саналтай байна.

М.Ариунбаяр: ГТГ техникийн зөвлөлөөр хэлэлцсэн бол тайлангаа Монгол хэл дээр ирүүлэхгүй яасан. Эдийн засаг, байгаль орчин, ус бүгд хамаатай. Хэрэгтэй үедээ олон улсын стандарт гэж яриад байна. “Дачин Тамсаг” дээр яг ингэж ярьсан. ГТГ-ыг стандартаа гаргаад ир гэсэн, гэтэл өнөөдрийг хүртэл байхгүй байна. Шинжээчдийн шаардлага зөв байна. “Петрочайна Дачин Тамсаг”-тай ижилхэн шийдвэр гаргахад хүрээд байна. Шинжээчдийн саналаар авах саналтай байна.

Ө.Оюунбаатар: Монгол улсад газрын тосны нөөцийн ангиллын стандарт алга. ГТГ стандартаа боловруул. Шинжээчдийн багт мэргэжлийн хүмүүсийг түлхүү оруулах тал дээр анхаарна. Дагалдах ашигт малтмал судлахгүй байна. Ураныг хэмж. Ганцхан газрын тос хайна гэсэн гэж болохгүй. Дагалдах ашигт малтмалыг судлах, энэ талаар тайланд тусган оруулах шаардлагатай. Шинжээчдийн хувилбараар нөөц авах саналтай байна.

Шийдвэрлэсэн нь:

Хурлын дарга Ө.Оюунбаатар “Шинжээчдийн хувилбараар нөөц авах”, “Компанийн хувилбараар нөөц авах” гэсэн 2 томъёололоор санал хураахад санал өгөх 20 гишүүний 10 нь “Компанийн хувилбараар нөөц авах”, 9 нь “Шинжээчдийн хувилбараар

нөөц авах” санал өгч, 1 гишүүн түдгэлзсэн тул олонхийн саналаар нөөцийг ГТГ-ын техникийн зөвлөлөөр дэмжигдсэн компанийн хувилбараар хүлээн авахаар шийдвэрлэлээ.

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



М.ТОДБИЛЭГ

